



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНГОВЬ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 8/02

Өргөн

Бэлчээр ашиглалтыг сайжруулах,  
хариуцлагажуулах журам батлах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 18 дугаар зүйлийн 18.1.2/з/ дэх заалт, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын "Бэлчээр ашиглалтыг сайжруулах, хариуцлагажуулах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг багийн иргэдэд сурталчлан таниулж, хэрэгжилтийг хангаж, тодорхой үр дүн гаргаж, шуурхай зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлэг үржлийн тасаг, багийн Засаг дарга, Бэлчээр Ашиглагчдын Холбооны ахлагч нарт зөвлөсүгэй.

3.Журмыг хэрэгжүүлж, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр гарган Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Эрдэнэбилэг/-д даалгасугай.

4.Тогтоолыг Хууль зүй Дотоод Хэргийн Яамны Хууль Зүйн Бодлогын Газрын Захиргааны Хэм Хэмжээний Актын Хяналт Бүртгэлийн Хэлтэст бүртгүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Чимэдцэрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА

В.БАТЖАРГАЛ



0417018

Баянговь сумын иргэдийн төлөөлөгчдийн  
2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн  
ээлжит 8 дугаар хуралдааны 8/2 дугаар  
тогтоолын хавсралт



## БАЯНГОВЬ СУМЫН БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ, ХАРИУЦЛАГАЖУУЛАХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Баянговь сум нь газрын нэгдмэл сангийн ангиллаар 466159 га газар нутагтай, 424511 га бэлчээрийн талбайтай. 2017 жилийн эцсийн хүн ам, малын тоогоор хонин толгойд шилжүүлснээр 293951 толгой мал тоолуулж бэлчээрийн даац 4 дахин хэтэрсэн байна.

Сумын хэмжээнд өвөл-хавар, зун-намрын гэсэн бэлчээр ашиглалтын хэлбэр зонхилдог боловч бэлчээр сэлгэх ойрын болон алсын отор нүүдэл хийх байдал үндсэндээ орхигдон ил задгай устай газрын бэлчээр талхлагдан доройтоод байна. Сум орон нутаг өөрсдөө бэлчээр нутгаа зүй зохистой ашиглаж хамгаалах асуудлаа хэлэлцэн шийдвэрлэж бие даан хөгжих, малчид, хот айл, малчдын бүлэг нөхөрлөл, бэлчээр ашиглагчдын хэлбэрт шилжих зайлшгүй шаардлага тавигдаж байна.

Сүүлийн 5 жилийн байдлаас харахад мал сүргийн тоо толгой жил дараалан өсч тэр хэрээр бэлчээрийн даац багтаамжийг хэтрүүлж байгаа бөгөөд өнгөрөгч 2017 онд сумын нийт нутгийн 70 хувь нь гантай, 30 орчим хувь нь гандуу байснаас мал сүрэг тарга хүчээ бүрэн авч чадаагүйн дээр бэлчээрийн даацыг 22 цэгт фото мониторингийн аргаар тооцож үзэхэд бэлчээрийн даац 4-10 дахин хэтэрсэн гэсэн судалгаа гарсан.

Бэлчээр доройтоход тэжээлийн үнэт ургамал цөөрч, аажмаар мөхдөгийн улмаас мал сүрэгт махан тарга авахуулдаг ургамал давжаарч, сийрэгждэг. Үүний улмаас ургамлын хооронд халцарч нүцгэрсэн газар ихсэн шороон шуурга элбэгшиж үржил шимт хөрс элэгдэлд ордог. Энэ бүхэн нь малд тохиромжгүй хог ургамал үржих, тархах таатай орчин бүрдүүлдэг ба бэлчээрийн үндсэн ургамал сэргэх нөхцлийг улам бүр хумьж байгаа зэргээс бэлчээр ашиглалтын талаар сум багт журмыг гарган хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гарч байна. Малчдын дийлэнх олонх нь бэлчээрийн ашиглалтын журам гаргахыг дэмжиж байна. Энэ журам нь газрын тухай хуулийн 20.1.2, 52.1, 52.2, 52.4, 52.6, хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.1.4-д заасан харилцаанд нийцсэн байна.

### ХОЁР. ЖУРМЫН ЗОРИЛГО ЗАРЧИМ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

Бэлчээр ашиглалтыг бэлчээрийн нөөц чадавхад тохируулах хариуцлагажуулахад эдийн засгийн хөшүүрэг бий болгох, бэлчээрийн даацад тохирсон мал сүрэг өсгөн үржүүлэх, МАА-н үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангах. Сумын хэмжээнд бэлчээрийн менежментийг тухайн орон нутгийн бэлчээрийн экологийн чадавхад суурилсан нэгдсэн аргачлалаар уян хатан төлөвлөх, зохицуулах хамгаалах, хяналт үнэлгээ хийх нөхөн

сэргээхтэй холбоотой харилцаа, энэ хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулахад зорилго оршино.

2.1. Журмыг хэрэгжүүлэхдээ бэлчээрийн экологийн чадавхад суурилсан, оролцогсодын тэгш оролцоог хангахад дор дурдсан зарчмыг баримтална. Үүнд:

2.1.1. Бэлчээрийн төлөв байдал, чанарт хяналт үнэлгээ хийх, хамгаалах, нөхөн сэргээх, сэлгэж өнжөөх амрах арга хэмжээг малчдын оролцоотойгоор төлөвлөн хэрэгжүүлнэ.

2.1.2. Бэлчээрийн экологийн чадавх бүтээмжит чанар даацад нь нийцүүлэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэнэ.

2.1.3. Улирлын бэлчээр, бэлчээр дэх бусад нөөц /хужир мараа, байгалийн усны ил эх үүсвэр/-ийг ашиглахад оролцогсдын тэгш байдлыг хангана.

2.2. Бэлчээр ашиглалтын чиглэлээр жил бүр хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх хэрэгжүүлэхдээ дор дурдсан зохицуулалтыг баримтална. Үүнд:

2.2.1. Бэлчээр ашиглалтын талаар тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж БИНХ-аар хэлэлцүүлнэ.

2.2.2. БИНХ-аар батлагдсан бэлчээр ашиглалтын төлөвлөгөө нь сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний үндэслэл болно.

2.2.3. Бэлчээр ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төсөл хөтөлбөрийн байгууллагууд, малчдын бүлэг бэлчээр ашиглагчдын хэсгийн чиглэлээр бэлчээр ашиглалтын төлөвлөгөө гарган төрийн байгууллагуудтай хамтран ажиллана.

2.2.4. Бэлчээрийн даацаас хэтэрсэн нэг хонин толгой тутмаас 500 төгрөгийн төлбөр авч бэлчээрийн санд төвлөрүүлнэ.

2.2.5. Тухайн жилд өнжөөж чөлөөлөх болон отрын бүс нутгийг сумын Засаг дарга өргөн мэдүүлснээр сумын ИТХ шийдвэрлэнэ.

#### ГУРАВ:БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫГ ХЯНАХ, БЭЛЧЭЭРИЙН ДААЦ ТООЦОХ

3.1. Сумын Засаг даргын даргын тамгын газар бэлчээрийн даацад үндэслэн тооцооллыг гаргаж жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны дотор багийн Засаг даргад зөвлөмж байдлаар хүргүүлнэ.

3.2. Багийн Засаг дарга энхүү зөвлөмжийн дагуу дараах арга хэмжээг тодорхойлж БИНХ-г хуралдуулах товыг 10 дугаар сарын 01-ны дотор гаргана.

3.2.1. Малчин өрх тус бүрийн өвөлжүүлэх малын тооны дээд хязгаарыг 6.3.2-т зааснаар тогтооно.

3.2.2. Журмын хүрээнд бэлчээрийн хөрөнгө оруулалтаас чөлөөлөгдөх болон төлбөр хийх малчдын нэрсийг багийн засаг дарга гаргаж БИНХ-аар хэлэлцүүлнэ.

3.2.3. Бэлчээрийн даац хүрэлцээтэй нөхцөлд гаднаас өвөлжүүлэх малын тоо толгойн дээд хэмжээ хязгаар, "Бэлчээрийн сан"-д төвлөрүүлэх төлбөр тогтооно/хонин толгойгоор/.

3.3. БИНХ жил бүрийн 10 дугаар сарын 15-ны дотор хуралдаж дээрх асуудлыг ардчилсан зарчмаар нийтэд нээлттэй хэлэлцэж олонхийн саналаар шийднэ.

3.4. Тухайн жилийн мал тооллогын дүнд тулгуурлан бэлчээрийн санд төвлөрүүлэх төлбөрийн хэмжээг Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг тогтоож, БИНХ-ын дарга, багийн дарга нар иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллага, малчин өрхүүдээс дараа оны 06 дугаар сарын 01-ны дотор төлбөрийг бэлчээрийн санд төвлөрүүлнэ.

3.5. Тавиул малын тухай.

3.5.1. Тухайн сум ороннутгийн харьяалал бүхий иргэний малыг маллаж байгаа малчнаас малыг хонин толгойд шилжүүлэн бэлчээрийн даац хэтрүүлсэн гэж үзэн төлбөр оногдуулна.

3.5.2. Гадны сум орон нутгийн харьяалалтай иргэний малыг маллаж байгаа малчнаас тухайн малыг хонин толгойд шилжүүлэн бэлчээрийн даац хэтрүүлсэн төлбөр болон малаа маллуулж байгаа иргэнээс төлбөрийг 5.1.3-т зааснаар давхардуулж авна.

3.5.3. Мал маллаж байгаад тэтгэвэрт гарсан ахмад настангуудын өөрийн асран хамгаалагч нь тавиул малыг малладаг бол хонин толгойд шилжүүлснээр 50 малыг төлбөрөөс чөлөөлнө.

3.5.4. Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн тавиул малыг хонин толгойд шилжүүлэн журмын дагуу төлбөр төлнө.

3.6. Тухайн БИНХ нь жил бүрийн 05 дугаар сарын 01-ний дотор хуралдаж өмнөх жилийн гүйцэтгэлийг тайлагнах, багийн "Бэлчээрийн сан"-д тухайн онд төвлөрүүлэх нийт төлбөрийн хувь хэмжээ тухайн жилд хийх ажлыг төлөвлөх зэрэг асуудлыг хэлэлцэнэ.

#### ДӨРӨВ. ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮҮРЭГ ОРОЛЦОО

4.1. Мал эмнэлэг үржлийн тасаг

4.1.1. Бэлчээр ашиглагчид, малчдад уламжлалт бэлчээр ашиглат, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, сайжруулах талаар сургалт зохион байгуулан бэлчээрийг зөв ашиглах дадлыг бий болгоход туслана.

4.1.2. Фото мониторингийн дүн мэдээлэлд тулгуурлан тухайн жилд малын тоо толгойг бэлчээрийн даацад нийцүүлэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээ сүргийн зохистой бүтэц, харьцаа, шилэн сонголт чанар болон МАА менежментийн бусад асуудлаар зөвлөмж гаргаж, тэгжилтэд дэмжлэг үзүүлнэ.

4.2. Ус, цаг уурын өртөө

4.2.1. Фото мониторингийн цэгийн тоог нэмэгдүүлэн, 08 дугаар сарын 10-20-ны сум, багийн бэлчээр ашиглагчдын хэсэгтэй хамтран фото мониторингийн аргаар усны хэмжээг тодорхойлж, холбогдох байгууллагуудыг үнэн зөв мэдээллээр хангана.

4.2.2. Бэлчээрийн даац муудсан, ган гачиг болсон газарт үүлэнд зориудаар нөлөөлөх, БИНХ-аас газрын генератор байрлуулах санал гарсан тохиолдолд түүнийг байршуулж мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангана.

#### 4.3. Газрын даамал

4.3.1. Бэлчээр болон хадлангийн талбайд фото мониторинг хийж, тухайн жилийн болон олон жилийн дундажтай харьцуулсан дүнг малчид, орон нутгийн удирдлагад мэдээлэн, бэлчээр ашиглагчдын хэсэг, багийн тухайн жилийн ажлыг дүгнэх, дараа жилийн ажлыг төлөвлөхөд суурь мэдээлэл болгож ашигладаг байдлыг хэвшүүлнэ.

4.3.2. Газрын тухай хуулийн 58.5-д заасны дагуу бэлчээр, хадлангийн газрын төлөв байдал чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

4.3.3. Бэлчээр ашиглагчдтай гэрээ байгуулахад шаардагдах хавсралт, зурган мэдээлэл гаргах бэлчээр ашиглагчдын гэрээг газрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, фото мониторингийн дүнд үндэслэн гэрээний хэрэгжилтийг үнэлэн тайлагнана.

4.3.4. Өвөлжөө, хаваржаа, уст цэгийн байршлыг тогтоож мэдээллийн сан үүсгэн, тогтмол шинэчлэн сайжруулна.

4.3.5. Сумын хилийн маргаантай байгаа асуудлыг судлан нэгдсэн ойлголтонд хүрч зохих арга хэмжээний хүрээнд шийдвэрлүүлнэ.

#### ТАВ. СУМЫН ИТХ, ЗАСАГ ДАРГЫН БОЛОН МАЛЧДЫН ЧИГ ҮҮРЭГ

##### 5.1.1 сумын ИТХ-ын чмг үүрэг

5.1.1. Сумын бэлчээр ашиглалтыг сайжруулах, хариуцлагажуулах журмыг хэлэлцэн батлаж багийн Засаг дарга нарт үүрэг, чиглэл, албан даалгавар, арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

5.1.2. Журмын хүрээнд үлгэр жишээ ажиллаж байгаа иргэн, БАХ, малчдын бүлэг, хоршоонд давуу эрхээр улсын төсөв болон ОНХСангаас хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

5.1.3. Өөр аймаг, сум, багаас орж ирсэн малаас авах төлбөрийн дээд хэмжээг хонин толгойд шилжүүлснээр нэг хоногт 250 төгрөг байхаар тооцож тогтооно.

5.1.4. Бизнесийн зорилгоор олон тооны мал суурилсан бол нэг хонин толгойд нэг хоногт 200 төгрөгөөр бодож төлбөр тогтооно.

5.1.5. Сумын хэмжээнд хэрэгжүүлэх бэлчээрийг хариуцлагажуулах нэгдсэн журмыг баталж мөрдүүлнэ.

5.1.6. Бэлчээр ашиглалтыг сайжруулах, хариуцлагажуулах журмын хүрээнд үлгэр жишээ ажиллаж буй малчдыг төрийн дээд одон медаль болон Улс, Аймаг сумын аврага малчинд тодорхойлно.

5.1.7. Бэлчээрийн сангийн зарцуулалт, бүрдүүлэлтэнд ИТХ хяналт тавьж ажиллана.

##### 5.2. БИНХ-ын чиг үүрэг

5.2.1. Бэлчээр ашиглалтыг сайжруулах, хариуцлагажуулах журмыг хэлэлцүүлж саналаа сумын ИТХ-д уламжилна.

5.2.2. Тухайн жилд хийгдэх ажлын жагсаалт, зарцуулах санхүүгийн эх үүсвэрийг БИНХ-р хэлэлцэн санал хүргүүлэх

5.2.3. Өөрийн сум орон нутгийн малчдын тэмээг төлбөрөөс чөлөөлж гадны аймаг, сумын малчдын тэмээ орж ирсэн тохиолдолд 3.5.2-т зааснаар төлбөр авна.

5.2.4. Сумын хэмжээнд нэгдсэн нэг сантай байх ба бэлчээрийн сан бүрдүүлэлт, зарцуулалтанд хяналт тавина.

5.2.5. Энэ журмын 5.2.2, 5.3.7 дэх заалтыг үндэслэн отроор өвөлжиж хаваржих малыг тоо хязгаарын хэлэцэн шийдвэрлэх.

5.2.6. Тухайн багийн нутагт фото мониторингийн судалгаа хийж болох оновчтой цэгүүдийг тогтоож болно.

5.2.7. Тухайн багийн бэлчээрт өөр аймаг, сумын нутгаас отроор өвөлжиж хаваржиж болох малын тооны дээд хязгаарыг тогтооно.

### 5.3. Сумын Засаг даргын чиг үүрэг

5.3.1. Багийн Засаг даргын ажлын үнэлгээг гаргахдаа бэлчээрийн менежментийн төлөвлөгөө, бэлчээр ашиглалтыг сайжруулах, хариуцлагажуулах журмын хэрэгжилтийн үр дүнг үндэслэн тооцдог байна.

5.3.2. Бэлчээр ашиглалтыг сайжруулах, хариуцлагажуулах журмыг мөрдөн ажиллаж байгаа баг малчин өрхөд хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх төрийн дээд одон медальд тодорхойлно.

5.3.3. Сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулж, сумын ИТХ-аар хэлэлцүүлэн, хэрэгжилтийг зохион байгуулна.

5.3.4. Тухайн бэлчээр нутгийг өнжөөх, амраах, сэлгэх, чөлөөлөх тухай шийдвэр гаргаж холбогдох иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллага, малчдаар мөрдүүлэх.

5.3.5. БИНХ-ын тогтоолыг үндэслэн малчдын бүлэг, нөхөрлөл, бэлчээр ашиглагчдын хэсэгт газрын тухай хуулийн 52.2-т заасны дагуу бэлчээрийг урт хугацаагаар гэрээгээр ашиглуулах, гэрээний хэрэгжилтийг дүгнэж, үр дүнг тооцож ажиллана.

5.3.6. Гол, горхи, булаг, шандны эх ундаргыг хамгаалахаас бусад тохиолдолд бэлчээрийг хашиж хамгаалахыг зогсооно.

5.3.7. Тухайн сумын бэлчээрт өөр аймаг, сумын нутгаас отроор өвөлжиж, хаваржих малыг оруулахдаа журамд нийцүүлэн, холбогдох субъекттэй зөвшилцөж, журамд заасан төлбөрийг төлүүлэн, гэрээ байгуулж, бэлчээр нутгийг тогтоож өгнө.

5.3.8. Багийн малчин өрхүүдийн хуримтлуулсан төлбөрийг сумын бэлчээрийн санд төвлөрүүлж тухайн БИНХ-аас шийдвэрлэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд санхүүжүүлнэ.

### 5.4. Багийн Засаг даргын чиг үүрэг

5.4.1. Сумын бэлчээрийн ашиглалтыг хариуцлагажуулах журмын хэрэгжилтийг БИНХ-аар хэлэлцүүлж үнэлэлт, дүгнэлт өгсөн тухай шийдвэрийг дараагийн шатанд уламжилна.

5.4.2. Тогтоосон төлбөрийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, малчдаас хураан авч бэлчээрийн санд төвлөрүүлнэ.

5.4.3. Тухайн жилд бэлчээрийн санд хуримтлагдах хөрөнгийг сумын нэгдсэн дансанд төвлөрүүлэх, БИНХ-ын шийдвэрийн дагуу дээд шатны байгууллагад саналаа хүргүүлнэ.

5.4.4. Сумын Засаг даргын гаргасан шийдвэр, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах.

#### 5.5. Малчдын үүрэг

5.5.1. Малчдын бүлэг, нөхөрлөл, бэлчээр ашиглагчдын хэсэг зэрэг хамт олны зохион байгуулалтад нэгдэж бэлчээр ашиглах үйл ажиллагаанд оролцоно.

5.5.2. Бэлчээрийн даацад тохирсон малыг өсгөн, үржүүлэх бөгөөд бэлчээрийн даацаас хэтэрсэн малыг хонин толгойд шилжүүлэн тогтоосон төлбөрийг хугацаанд нь сумын бэлчээрийн санд төвлөрүүлнэ.

5.5.3. БИНХ, өдөрлөг, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах зэрэг олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох.

5.5.4. Бэлчээрийг өнжөөж, чөлөөлөх, сэлгэх, отор нүүдэл хийх талаар гарсан шийдвэрийг дагаж биелүүлнэ.

5.5.5. Гаднаас дур мэдэж айл өрх, мал сүрэг оруулж ирэх, өвөлжөө, хаваржаа, хонд бууцыг бусдад дамжуулан ашиглуулах, худалдахыг хориглоно.

5.5.6. Бэлчээрт байгаа малын сэг зэм, хог хаягдлыг цэвэрлэнэ.

5.5.7. Энэ журмын 5.5.5, 5.5.6 дахь заалтуудыг зөрчсөн бол олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрөөр малжуулах болон хөнгөлөлтэй зээл тусламжид хамруулахгүй байх.

5.5.8. Энэхүү журмыг дагаж мөрдөөгүй тохиолдолд улс, аймаг, сумын аварга малчин болон төрийн шагнал урамшуулалд нэр дэвшүүлэхгүй.

### ЗУРГАА. ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР, ЗАРЦУУЛАЛТ

6.1. Бэлчээрийн сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

6.1.1. Иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллага, малчдын төлбөр.

6.1.2. Бэлчээрийн санд нь тухайн багаас хуримтлагдсан хөрөнгийн хэмжээтэй тэнцэх санхүүгийн эх үүсвэрээр аймгийн ОНХС-аас дэмжлэг үзүүлэх.

6.1.3. Төсөл хөтөлбөр, хандивлагч байгууллагын дэмжлэг.

6.1.4. Бусад эх үүсвэр.

6.2. Сангийн хөрөнгийг зөвхөн дараах арга хэмжээнд зарцуулна.

6.2.1. Доройтсон, хэт доройтсон бэлчээрийг нөхөн сэргээхэд чиглэсэн үйл ажиллагаанд /бусад малчдын эрх ашгийг хөндөхгүйгээр/.

6.2.2. Ашиглагдахгүй бэлчээрийг ашиглах зорилгоор хөв, цөөрөм, худаг ус, бэлчээрийн усан сан байгуулах.

6.2.3. Багийн хэмжээнд ашиглах хадлан тэжээлийн талбай бий болгох.

6.2.4. Инженерийн хийцтэй худаг уст цэг болон нийтийг хамарсан бэлчээрт мод, бут, сөөг, тариалах.

6.2.5. Өөр аймаг, сумд отроор яваа малчин өрхөд шаардлагатай бол сангаас малын эрүүл мэнд, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, хашаа хороогоо засаж сайжруулах, малчны эрүүл мэндэд хүндрэл учирсан тохиолдолд нэг удаа дэмжлэг үзүүлж болно.

6.2.6. Бэлчээрийн санд төлбөрийг хугацаанд нь бүрэн төвлөрүүлсэн БИНХ-ын дарга, БЗД нарт тухайн багаас төвлөрсөн нийт төлбөрийн 10 хувиар урамшуулал олгоно.

6.2.7. Бэлчээрийн сангийн зарцуулалтыг сумын Засаг дарга, Санхүүгийн албаны дарга нар нэг, хоёр дугаар гарын үсэг зурж захиран зарцуулах эрх үүснэ.

6.3. Чөлөөлөгдөх нөхцөл

6.3.1. Тухайн баг, сумын нутаг дэвсгэрийн 50-аас доошгүй хувь нь гантай байсан нь тогтоогдсон үед нийт малчин өрх.

6.3.2. Малчин өрхийн ам бүлийн тооноос хамаарч нэг иргэнд хонин толгойд шилжүүлснээр 100 толгой мал.

6.3.3. Тэмээн сүргийг өсгөж нэмэгдүүлэх, үүлдэрлэг байдал чанарыг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор тус тус чөлөөлнө.

#### ДОЛОО. ХОРИГЛОХ ЗҮЙЛ

7.1. Бэлчээр ашиглахад дараах үйл ажиллагааг бүрэн хориглоно.

7.1.1. Тогтоосон журмын дагуу нэгдсэн зохицуулалтаар малаас чөлөөлсөн бэлчээрт түүний ойр орчинд дураар мал оруулах

7.1.2. Улирлын бэлчээрээс бусад газарт дур мэдэн нутаглах, бэлчээр ашиглалтын хувиар болон гэрээний заалтыг зөрчих, хог хаягдал, хортой зүйлс, шавхай бууц, сэг зэмийг хаяг, хашаа хороо, өтөг бууц, бэлчээр, усны эх үүсвэрийг бохирдуулах.

7.1.3. Дур мэдэж өвөлжөө, хаваржаа барих нийтийн бэлчээрийн талбайг хашиж хамгаалах.

7.1.4. Бусдын малыг дур мэдэн оруулж бэлчээрийн ачааллыг хэтрүүлэх.

7.1.5. Өвөлжөө, хаваржаагаа чөлөөлөн нүүж явсан айл өрхийн өвөлжөө, хаваржааны бэлчээрийг дур мэдэн ашиглах/өвөлжөө, хаваржааг ашиглах журамд заасан хэмжээг баримтална/.

7.1.6. Мал, мах бэлтгэл, отор, нүүдэл хийх, өөр аймаг, сумдад малын шилжилт хөдөлгөөн хийх зорилгоор мал тууварлахдаа малчны бүлгийн нутагдэвсгэрээр 2 хоногоос илүүгүй хугацаанд тогтоосон газар нутгаар дамжин өнгөрнө.

7.1.7. Малын урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдаагүй, эрүүл мэндийн дэвтэргүй малчны малыг сум, багийн нутаг дэвсгэрт оруулах зэргийг тус тус хориглоно.



7.1.8. Гол горхи, уст цэг бүхий бэлчээрийн газрыг заасан хугацаанд чөлөөлж, тухайн хугацаанд ашиглахыг хориглоно.

#### НАЙМ. ХАРИУЦЛАГА

8.1. Бэлчээр ашиглалттай холбоотой зөрчил хариуцлагын асуудлыг дараах нөхцөлд авч үзнэ.

8.1.1. Журмын 7.1.1, 7.1.2, 7.1.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн бол 2.2.4 дахь заалтыг үнэлгээг 3 дахин нугалж төлүүлнэ.

8.1.2. Бусдын малыг дур мэдэн оруулах, бэлчээр нутаг хашаа, хороо, уст цэгийг үнэлж дамжуулан ашиглуулсан, худалдсан болон 7.1.6 дахь заалтуудыг зөрсөн тохиолдолд журмын 5.1.3 дахь заалтыг 3 дахин нугалж төлүүлнэ.

8.1.3. Энэ журмын 7.1.5 дахь заалтыг зөрчвөл тухайн малчны малын тоог хонин толгойд шилжүүлснээр нэг хонин толгойд хоногийн 500 бэлчээрийн санд төлбөрийг төлүүлэх арга хэмжээ авна.

8.1.4. Энэ журмын 7.1.7 дахь заалтыг зөрчсөн тохиолдолд худалдаж авсан малыг хонин толгойд шилжүүлэн 2.2.4 дахь заалтыг 10 дахин, өөр аймаг, сумын харьяалалтай иргэний малаас 5.1.3 дахь заалтыг 5 дахин нэмэгдүүлж төлбөрийг төлүүлнэ.

8.1.5. Журмын 7.1.8 дахь заалтыг зөрчсөн тохиолдолд 2.2.4 дахь заалтыг 5 дахин нэмэгдүүлж төлбөрийг төлүүлнэ.

8.1.6. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг биелүүлэхээс хүндэтгэх шалтгаангүйгээр удаа дараа татгалзсан малчнаар 2.2.4 дахь заалтыг 5 дахин нэмэгдүүлж төлүүлнэ.

8.1.7. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг биелүүлэхээс хүндэтгэх шалтгаангүйгээр удаа дараа татгалзаж хүндрэл учруулбал 2.2.4 дэх заалтыг 10 дахин нэмэгдүүлж төлүүлнэ.

8.1.8. Энэ журмын 2.2.4 дэх заалтыг зөрчсөн тохиолдолд 3 дахин нугалж төлнө.

8.1.9. Журмын хэрэгжилтийг санаатайгаар мушгин гуйвуулж малчдад сөрөг мэдээлэл өгсөн иргэн, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

8.1.10. Журамтай холбоотой бусад маргааныг БИНХ-аар хэлэлцэж шийдвэрлэх ба шаардлагатай тохиолдолд холбогдох хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

#### ЕС. ЖУРАМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, ХҮЧИНТЭЙ ҮЙЛЧЛЭХ ХУГАЦАА

9.1. Энэхүү журмыг 2018 оны 09 сарын 01-ээс эхлэн дагаж мөрдөнө.